



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 558

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын ерөнхий прокурорын газрын харьяа газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 3 нэрийн нийт 54,999,999.96 (тавин дөрвөн сая есөн зуун ерэн есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг ерэн зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, 51,791,666.61 (тавин нэгэн сая долоон зуун ерэн нэгэн мянга зургаан зуун жаран зургаан төгрөг жаран нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, хавсралтад заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132003528
25-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 1-дүгээр сарын 31-ний өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ХАРЪЯА ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашин шилжүүлэх байгууллагын нэр	Суудлын автомашины нэр, төрөл	Улсын		Автомашинны арлын дугаар	Үйлдвэрлэсэн огноо	Балансын үнэ (төгрөг) (2024.04.30)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг) (2024.04.30)	Цаашид ашиглах хугацаа (жил)	Цаашид шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	Автомашин хүлээн авах байгууллагын нэр
			сери	№								
1	Дорнод аймгийн Прокурорын газар	Ниссан патрол	ХӨВ	80-00	JN1TCSY61Z0581045	2011	10,999,999.96	7,791,666.61	3,208,333.35			Сүхбаатар аймаг дахь Мал эмнэлгийн газар
2	Сэлэнгэ аймгийн Прокурорын газар	Ниссан Патрол	СЭА	09-00	JN1TCSY61Z0581257	2011	22,000,000.00	22,000,000.00	-	3	21,000,000.00	Дорноговь аймаг дахь Мал эмнэлгийн газар
3	Булган аймгийн Прокурорын газар	Ниссан Патрол	БУА	08-00	JN1TCSY61Z0580867	2011	22,000,000.00	22,000,000.00	-	3	21,000,000.00	Говь-Алтай аймаг дахь Мал эмнэлгийн газар
НИЙТ ДҮН												
							54,999,999.96	51,791,666.61	3,208,333.35		42,000,000.00	
							(тавин дөрвөн сая есөн зуун ерэн есөн мянга есөн зуун ерэн төгрөг эрэн зургаан мянгэ мөнгө)	(тавин нэгэн сая долоон зуун ерэн нэгэн мянга зургаан зуун жаран зургаан төгрөг жаран нэгэн мянгэ мөнгө)	(гурван сая хоёр зуун найман мянга гурван зуун гучин гурван төгрөг гучин таван мөнгө)		(дөчин хоёр сая)	